

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГИЙН СУДАЛГАА

О.Пүрэвдорж*, О.Нүржигмаа**

Хураангуй: Санхүүгийн хяналт шалгалт нь мэргэжлийн түвшинд хийгддэг хяналт шалгалт бөгөөд манай улсын хувьд төрөөс санхүүгийн хяналт шалгалтыг төрийн аудитын болон төрийн захиргааны хяналт шалгалт гэсэн хоёр үндсэн чиглэлээр хийж байна. Энэхүү судалгааны ажилд санхүүгийн хяналт шалгалтын төрөл, ангилал, хяналт шалгалтын үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчим, хяналт шалгалт хийх арга зүйг онолын хувьд авч үзэхийн зэрэгцээ төрөөс аж ахуйн нэгж, байгууллагуудад хийгдэж буй санхүүгийн хяналт шалгалтуудын үр дүнд динамик судалгаа хийж, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргаар үнэлэлт, дүгнэлт өгсөн болно.

Түлхүүр үгс: Санхүүгийн хяналт шалгалт, Төрийн аудит, Татварын хяналт шалгалт

RESEARCH OF FINANCIAL CONTROL RESULTS

Abstract: Financial control is carried out under the professional level and Government has been conducted financial control in two main areas which are state audit and public administration control in Mongolia. This research has considered that financial control's type classification, and major principles are based on theoretical methodology. Therefore the result of financial control conducted by Government into the enterprises and organizations which are summarized and evaluated by analytical and summarizing method.

Keywords: Financial control, State audit, Tax control

* МУИС, Худалдаа үйлдвэрлэлийн сургууль, (E-mail): purevdorj.o@nucb.edu.mn

** МУИС, Худалдаа үйлдвэрлэлийн сургууль, (E-mail): Nurjigmaa@nucb.edu.mn

Онолын хэсэг

Хяналт шалгалт гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн явуулж байгаа үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/, түүнчлэн үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хянан шалгах арга хэмжээний цогцолборыг хэлнэ [13].

Мэргэжлийн түвшинд хийгддэг хяналт шалгалтын нэг хэлбэр нь санхүүгийн хяналт шалгалт юм.

Санхүүгийн хяналт шалгалт гэдэг нь аж ахуйн үйл ажиллагааны бүхэл үе шатанд хөрөнгийн хөдөлгөөн нь хууль тогтоомжид заасан хэм хэмжээтэйгээ нийцэж байгааг үндсэн баримтаар нь тулган шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааг хэлнэ [9].

Санхүүгийн хяналт шалгалт нь санхүүгийн удирдлагын салшгүй хэсэг ба санхүүгийн хуваарилалтын, хяналтын үүргийн мөн чанараас урган гарсан удирдлагын гол хэрэгсэл юм.

Санхүүгийн хяналт шалгалтын зорилго нь:

1. Санхүүгийн үйл ажиллагаандаа санхүүгийн сахилгыг мөрдөх нөхцөлийг хангах;
2. Санхүүгийн эрх зүйн харилцаанд оролцогчдын хууль тогтоомжийн мөрдөлтийн байдлыг тогтоох;
3. Санхүүгийн нөөцийн захиран зарцуулалтыг үр ашигтай, үр дүнтэй болгох;
4. Хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Санхүүгийн хяналт шалгалтын бусад хяналт шалгалтаас ялгагдах онцлог нь үйлчлэх хүрээ, хамрах объект, субъектээр илэрнэ.

Үйлчлэх хүрээ нь хөрөнгө хуримтлуулах, хуваарилах, ашиглах, санхүүгийн эрх зүйн харилцаанд оролцогчдын эдлэх эрх, үүрэг, түүнийг зөрчсөнөөс үүсэх хууль зүйн хариуцлага хүлээх чадвар бүхий субъектүүдийн харилцаа юм.

Субъект нь санхүүгийн харилцаанд оролцож буй бүх төрлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд буюу хяналт шалгалт хийх эрх бүхий этгээдүүд болно.

Объект нь санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, зарцуулах үүрэгтэй бүх төрлийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаагаар илэрч буй санхүүгийн харилцаа юм.

Санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим:

1. *Хууль сахих:* Хяналт шалгалтын үйл ажиллагааг хуулийн хүрээнд

явуулах,

2. *Шударга байх*: Шалгалтад хамрагдаж буй ямар ч этгээдэд шударга хандахын зэрэгцээ шалгалттай холбоотой асуудлаар тайлбар гаргах эрхээр хангах,
3. *Тэгш хандах*: Шалгуулагч бүрт адил нөхцөл байдалд ижил хандах,
4. *Нууцыг хадгалдаг байх*: Өөрийн үүргээ гүйцэтгэхээс бусад тохиолдолд шалгуулагчийн талаарх мэдээллийг задруулахгүй байх,
5. *Тусалцаа үзүүлдэг байх*: Хууль тогтоомжийн талаар зөвлөгөө, тусалцаа үзүүлдэг байх,
6. *Мэргэжлийн үзэл бодолтойгоор хандах*: Хяналт шалгалтад аливаа хөндлөнгийн зүйлд автагдахгүйгээр зөвхөн хуулийн хүрээнд ажилладаг байх,
7. *Мэргэжлийн ур чадвартай байх*: Харилцааны болон мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн байх.

Санхүүгийн хяналт шалгалт хийх үндсэн аргууд:


1. Индукцийн арга: Анхан шатны баримтаас хөөн шалгах арга
2. Дедукцийн арга: Санхүүгийн тайлангаас анхан шатны баримт руу хөөн шалгах арга
3. Тооллогын арга: Бараа материал, биет зүйлийн тооллого хийж, бүртгэлтэй тулган шалгах арга
4. Тулган баталгаажуулах арга: Бүртгэлийн баримтуудыг хооронд нь тулган шалгах арга
5. Давтан гүйцэтгэх арга: Ажил гүйлгээг дахин бүртгэж, бүртгэлтэй нь тулган шалгах арга
6. Ерөнхийлөн ажиглах арга: Бүртгэлийг бүхэлд нь шалгах аас өмнө ерөнхий дүгнэлт өгөх арга
7. Шинжилгээний арга: Санхүүгийн тайлангийн болон бусад үзүүлэлтүүдийг харьцуулан шинжлэх арга
8. Экспертийн үнэлгээний арга: Мэргэжлийн шинжээч шалгалт хийж, дүгнэлт өгөх арга
9. Асуулгын арга: Тодорхой асуултууд бэлтгэн хариулт авах замаар дүгнэлт гаргах арга
10. Ярилцлагын арга: Тодорхой асуудлын талаар холбогдох хүмүүстэй ярилцаж, тэмдэглэл хөтлөн дүгнэлтдээ ашиглах арга

11. Ажлын зураг авалт хийх арга: Байгууллагын үйл ажиллагааг ажиглан, дүгнэлт өгөх арга

Санхүүгийн хяналт шалгалт хийх үе шатууд:

1. Хяналт шалгалтын бэлтгэл ба эхлэх үе шат: Шалгуулах байгууллагын талаарх мэдээлэл цуглуулж судлах, шалгалтын удирдамж боловсруулж батлуулах, шалгуулах байгууллагад урьдчилан мэдэгдэх зэрэг ажлууд хийгдэнэ.
2. Хяналт шалгалтыг гүйцэтгэх үе шат: Шалгалт хийх ажлын хэсэг удирдамжид заасан хугацаанд шалгалтыг явуулж шалгалтын дүгнэлтийг гаргах хүртэл хийгдэх ажлууд хамрагдана.
3. Хяналт шалгалтын ажлыг дүгнэх үе шат: Шалгалт хийсэн ажлын хэсэг шалгалтын материалаа нэгтгэн дүгнэсэн саналаа гаргах буюу шалгалтын материалаа батлуулан эцэслэн шийдвэрлэх ажлууд хамрагдана.

Монгол улсын хувьд санхүүгийн хяналт шалгалтын тогтолцоог дараах байдлаар тодорхойлж болно.



Төрийн аудитын хяналт шалгалт:

Төрийн аудитын байгууллага нь улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд хийж байгаа хяналт шалгалт байна.

Төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалт:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, аймаг нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас хэрэгжүүлж байсан санхүүгийн хяналт шалгалтын үндсэн чиг үүргийг 2014 оноос эхлэн сангийн яам, бусад яамдын хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар, аймаг, нийслэлийн засаг даргад шилжүүлснээр санхүүгийн хяналт, дотоод аудит, хяналт шинжилгээ үнэлгээ хийх гэсэн 3 өөр чиг үүргийг нэгтгэсэн холимог бүтэцтэй тогтолцоо бий болсон байна. Ингэснээр санхүүгийн хяналт шалгалтын бодлого зорилтыг сангийн яам тодорхойлж засгийн газрын нэрийн өмнөөс гүйцэтгэх засаглалын санхүүгийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байна. Санхүүгийн хяналт шалгалтыг ЗГХЭГ, Яам, аймаг, нийслэлийн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторуд гүйцэтгэж байна.

Татварын хяналт шалгалт:

Татварын хуулийг дагаж мөрдүүлэх, сахиулах, зөрчлийг илрүүлэх, хариуцлага хүлээлгэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор татварын байгууллагаас хэрэгжүүлж байгаа хяналт шалгалт юм.

Банкны хяналт шалгалт:

Банкны системийн тогтвортой байдал, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор арилжааны банкуудад төв банкнаас хийж байгаа санхүүгийн хяналт шалгалт. Мөн банкны тухай хуулийн 40.1-д заасны дагуу хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар жил бүр санхүүгийн тайлангаа баталгаажуулах шалгалт, банкны эздийн ашиг сонирхлын үүднээс банкны үйл ажиллагаанд хийж буй дотоод хяналт шалгалт хамаарна.

Нийгмийн даатгалын хяналт шалгалт:

Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор нийгмийн даатгалын

байгууллагаас хийж хяналт шалгалт юм.

Гаалийн хяналт шалгалт:

Гаалийн хяналт гэж монгол улсын нутаг дэвсгэрт гаалийн хууль тогтоомжийг мөрдүүлэх, түүний биелэлтийг хангуулах үүднээс гаалийн байгууллагын хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэлнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт:

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, харилцагч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, банкаас бусад санхүүгийн зах зээл болон үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагууд, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хийж байгаа хяналт шалгалт хамаарна.

Судалгааны хэсэг

Төрийн байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтын үр дүнгийн судалгаа

Төрийн аудитын байгууллагын хийсэн санхүүгийн тайлангийн болон бусад аудитын үр дүнгийн судалгаа

Санхүүгийн тайлангийн аудит нь үйлчлүүлэгч байгууллагын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол чухал бодлого ба нэмэлт тайлбар тодруулгуудыг холбогдох санхүүгийн тайлагналын стандартын дагуу үнэн зөв, шударгаар бэлтгэж толилуулсан эсэх талаар гадаад мэдээлэл хэрэглэгчдэд хамгийн дээд түвшний баталгаа өгөх зорилготой нэг төрлийн баталгаажуулах ажил юм. [14] Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2010-2021 онуудын хооронд Төсвийн ерөнхийлөн захирагчдын нэгтгэсэн болон улсын төсвийн байгууллагын орон нутгийн түвшинд нэгтгэсэн, улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нийт 44,410 санхүүгийн тайланд бие даан аудит хийсэн байна.

Хүснэгт 1. Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын шалгалтын үр дүн /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2010-2017	2018	2019	2020	2021	Нийт
1	Хийсэн аудитын тоо: Үүнээс	28,917	3,806	3,958	3,824	3,905	44,410
2	Зөрчилгүй санал дүгнэлт	23,826	3,293	3,446	3,386	3,348	37,299
3	Хязгаарлалтай санал дүгнэлт	4,254	459	455	398	509	6,075

4	Сөрөг санал дүгнэлт	533	27	41	24	38	663
5	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	304	27	16	16	10	373
6	Зөрчлийн дүн	61,552.9	14,006.8	4,247.0	9,365.7	9,489.1	98,661.5
7	Залруулсан зөрчил	25,392.5	12,109.9	1,535.9	4,653.7	4,179.8	47,871.8
8	Төлбөрийн акт	-	10.6	14.1	21.4	52.7	98.8
9	Албан шаардлага	-	905.6	523.6	1,898.3	1,815.0	5,142.5
10	Зөвлөмж	-	-	2,160.4	2,788.9	3,441.2	8,390.5
11	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	-	-	12.0	1.5	0.4	13.9
12	Хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн	-	-	0.8	1.9	0	2.7

Эх сурвалж: ҮАГ-ын тайлангаас судлаачийн хийсэн тойм

Санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалтаар сүүлийн 12 жилийн хугацаанд давхардсан тоогоор нийт 44,410 санхүүгийн тайланд аудит хийснээс 84% буюу 37,229 нь зөрчилгүй санал дүгнэлттэй, 13.6% буюу 6,075 нь хязгаарлалтай дүгнэлттэй, 1.5% буюу 663 нь сөрөг дүгнэлттэй, 0.9% буюу 373 нь дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. Аудитын шалгалтаар нийт санхүүгийн тайлангийн аудитын 16 орчим хувь нь алдаа дутагдал, зөрчилтэй байсан ба нийт 98,661.5 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитын тоо хэмжээ тогтвортой байгаа хэдий ч илрүүлсэн зөрчлийн хэмжээ 2020 болон 2021 онуудад өссөн байна.

Хүснэгт 2. Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын шалгалтын үр дүн /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	Нийт
1	Аудитын тоо	298	273	160	228	959
2	Хамруулсан байгууллага /давхардсан тоо/	8,737	7,399	14,660	7,174	37,970
3	Зөрчлийн дүн	4,772.5	4,782.7	3,482.5	602.0	13,639.7
5	Төлбөрийн акт	46.8	5.1	21.7	7.0	80.6
6	Албан шаардлага	1,297.1	1,468.3	399.4	396.1	3,560.9
7	Зөвлөмж	-	2,979.4	1,049.0	186.7	4,033.1
8	Хариуцлага тооцуулах санал	-	11.4	8.0	-	19.4
9	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	-	318.5	2,004.4	12.2	2,335.1

Эх сурвалж: ҮАГ-ын тайлангаас судлаачийн хийсэн тойм

Үндэсний аудитын газраас сүүлийн 4 жилийн хугацаанд 959 гүйцэтгэл, нийцлийн аудит хийж давхардсан тоогоор 37,970 байгууллагыг хамруулан 13,639.7 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн ба сүүлийн жилүүдэд илрүүлсэн зөрчлийн хэмжээ буурсан байна.

Хүснэгт 3.Төрийн аудитын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2010-2017	2018	2019	2020	2021	Нийт
1	Санхүүгийн тайлангийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ	2.13	3.68	1.07	2.45	2.43	2.22
2	Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ	-	0.55	0.65	0.24	0.08	0.36
3	Нэг байгууллагад ногдох нийт зөрчлийн хэмжээ	2.13	4.23	1.72	2.69	2.51	2.58

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тооцоолол

Дээрх тоо мэдээнээс харахад санхүүгийн тайлангийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ 2020, 2021 онд өссөн хандлага ажиглагдаж байна. Тухайлбал 2019 онд нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ 1.07 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 2.45 тэрбум төгрөг болж 129%-иар, 2021 онд 2.43 тэрбум төгрөг болж 127%-иар тус тус өссөн байна. Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ 2020, 2021 онд буурсан байна. Сүүлийн 12 жилийн хугацаанд төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн болон нийцэл, гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр нэг байгууллагад ногдох зөрчлийн дүн 2.58 тэрбум төгрөг байна. Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн хэмжээ арилахгүй, буурахгүй тогтвортой байгаа нь аудитын шалгалтын үр дүн хангалтгүй, төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бэлтгэх үйл ажиллагаа нь стандарт, хууль эрх зүйн хүрээнд нийцэхгүй байгааг харуулж байна.

Татварын албадын аж ахуйн нэгж байгууллагуудад хийсэн татварын хяналт шалгалтын үр дүнгийн судалгаа

Татварын албаны чиг үүрэгт татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татварын хуулийн хэрэгжилтэд хяналт тавих явдал багтсан байдаг. Иймээс татварын албанаас татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор аж ахуй нэгж байгууллагуудад 2-5 жилийн хугацаанд төлөвлөгөөт болон гэнэтийн шалгалтуудыг хийж зөрчил, дутагдлыг нь илрүүлэн нөхөн төлбөр, акт торгууль тавьж байна.

Хүснэгт 4. Татварын албадын актаар илрүүлсэн зөрчил, ногдуулсан төлбөр, төсөвт оруулсан төлбөр /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Шалгалт хийсэн тоо	11,951	10,050	4,947	5,408	4,999	6,207	5,406	2,338	51,306
Актын тоо	10,600	8,770	3,549	4,138	4,163	5,029	4,357	1,610	42,216
Хувийн жин	88.7%	87.3%	71.7%	76.5%	83.3%	81.0%	80.5%	68.9%	82.3%
Илрүүлсэн зөрчил	1,977.7	3,535.7	523.4	1,348.7	2,979.5	8,005.0	2,589.0	10,764.9	31,723.9
Ногдуулсан төлбөр	212.4	456.8	106.2	110.3	268.7	876.7	182.2	767.0	2,980.3
Төсөвт орсон	59.8	57.8	65.1	27.1	63.6	59.2	60.4	52.0	445.0
Нэг шалгалтад ногдох зөрчил	0.17	0.35	0.11	0.25	0.60	1.29	0.48	4.60	0.62
Нэг актад ногдох төлбөр	0.020	0.052	0.030	0.027	0.065	0.174	0.042	0.476	0.070

Эх сурвалж: ТЕГ-ын Хяналт шалгалт арга зүйн газрын мэдээллээс судлаачийн тооцоолол

Татварын албаны 2013-2020 оны хооронд хийсэн сүүлийн 8 жилийн хяналт шалгалтын дүнгээр 51,306 шалгалт хийснээс 82.3% буюу 42,216 зөрчил илэрсэн ба зөрчлийн мөнгөн дүн нь 31,723.9 тэрбум төгрөг, ногдуулсан төлбөр 2,980.3 тэрбум төгрөг байна. Хяналт шалгалтын тоо сүүлийн жилүүдэд буурсан хандлагатай байгаа боловч 2017 оноос хойн нэг шалгалтад ногдох зөрчлийн дүн болон нэг актад ногдох төлбөрийн хэмжээ өссөн байна. Тухайлбал 2013 онд нэг шалгалтад ногдох зөрчлийн хэмжээ 0.17 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 4.6 тэрбум төгрөг болон өссөн байна. Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил болон ногдуулсан төлбөрийн хэмжээ өсөх хандлагатай байгаа нь татварын хяналт шалгалтын үр дүн хангалтгүй, аж ахуйн нэгж, байгууллагууд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь харагдаж байна.

Төрийн захиргааны төв байгууллагуудаас хийсэн санхүүгийн хяналт шалгалтын үр дүнгийн судалгаа

ЗГХЭГ, Яам, аймаг, нийслэлийн санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторуудын 2016-2019 онуудад хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдлын судалгааг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 5. Санхүүгийн хяналт шалгалтын албан шаардлага, актын тоо, илрүүлсэн зөрчлийн дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	Нийт
Албан шаардлага тоо	686	727	708	689	2,810
Актын тоо	2,428	2,630	2,502	2,230	9,790
Нийт зөрчлийн дүн	59.32	188.02	365.69	378.81	991.84
Хувь	6%	19%	37%	38%	100%
Нэг актад ногдох зөрчлийн хэмжээ	0.024	0.071	0.146	0.170	0.101

Эх сурвалж: Сангийн яам СХЭУГ-ын мэдээллээс судлаачийн тооцоолол

Санхүүгийн хяналт шалгалтаар 2016-2019 онуудын нийт 2,810 албан шаардлага, 9,790 акт, 991,854.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн бөгөөд зөрчлийн хэмжээ сүүлийн жилүүдэд өссөн хандлагатай байна.

Хүснэгт 6. Санхүүгийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдал 2018-2019 он /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2018		2019		Нийт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Нийт шийдвэрлэсэн зөрчил	17,452.6	100%	22,404.5	100%	39,857.1	100%
2	Улсын төсөвт	11,078.0	63.5%	14,144.8	63.1%	25,222.8	63.3%
3	Тухайн байгууллагад	4,365.2	25.0%	3,795.0	16.9%	8,160.2	20.5%
4	Орон нутгийн төсөвт	1,456.6	8.3%	3,795.0	16.9%	5,251.6	13.2%
5	Хуулийн байгууллагад шилжүүлсэн	545.5	3.1%	669.7	3.0%	1,215.2	3.0%
6	Барагдуулсан торгууль	7.3	0.1%	-	-	7.3	-

Эх сурвалж: Сангийн яам СХЭУГ

Санхүүгийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл 2018 онд 17,452.6 сая төгрөг, 2019 онд 22,404.5 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлэсэн байна. Хоёр жилийн хугацаанд нийт шийдвэрлэсэн зөрчлийн 63.3%-ийг улсын төсөвт, 20.5%-ийг тухайн байгууллагад, 13.2%-ийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 3.0%-ийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Санхүүгийн хяналт шалгалтаар илэрч байгаа нийт зөрчлийн дүн нь сүүлийн жилүүдэд өссөн хандлагатай байна.

Нийгмийн даатгалын байгууллагаас аж ахуйн нэгж байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын үр дүнгийн судалгаа

Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүрэг нь нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах явдал юм. Энэ хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудад нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалтын ажлыг хийж байна. 2013-2017 оны хяналт, шалгалтын үр дүнг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Нийгмийн даатгалын байгууллагаас 2013-2017 оны актаар илрүүлсэн зөрчил /сая төгрөг/

№	Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017	Нийт
1	Тавигдсан акт тоо	150	169	120	38	54	531
2	Илрүүлсэн зөрчил	309.6	2,133.8	887.8	281.5	1,051.3	4,664.0
3	Хувь	6.6%	45.8%	19.0%	6.0%	22.6%	100%
4	Нэг актад ногдох зөрчил	2.06	12.63	7.39	7.41	19.47	8.78

Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Нийгмийн даатгалын байгууллагаас аж ахуй нэгж, байгууллагад хийсэн хяналт, шалгалтын 2013-2017 онуудын 5 жилийн нийт дүнгээр 4,664.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 531 аж ахуй нэгж, байгууллагад акт тавьсан байна. Тавигдсан актын тоо хэмжээ буурсан боловч илрүүлсэн зөрчлийн мөнгөн дүн өссөн байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалттай байгууллагуудад хийсэн хяналт шалгалтын үр дүнгийн судалгаа

Санхүүгийн зохицуулах хороо нь зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, бусад шаардлага, шалгуурыг зайнаас хянаж, газар дээр нь шалгах, хяналт тавих, зохицуулалттай этгээдийн зохистой харьцаа алдагдаж төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд хууль тогтоомж, журамд заасан албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлээр хяналт шалгалтыг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 8. Санхүүгийн зохицуулах хорооны 2017-2020 онуудад зайнаас хийсэн хяналт шалгалтын үр дүн /сая төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2017	2018	2019	2020	Нийт
1	Хяналт шалгалт хийсэн санхүүгийн тайлан	3,612	9,314	10,573	8,742	32,241
2	Албан шаардлага хүргүүлсэн тоо	115	54	89	72	330

3	Ногдуулсан торгууль шийтгэл	Төгрөг	81.9	365.6	213.7	180.0	841.2
		Хувь	10.0%	43.5%	25.4%	21.4%	100%
4	Биелэлтийг хангуулсан		81.9	144.9	213.7	80.6	521.1
5	Нэг шалгалтад ногдох торгууль		0.022	0.039	0.020	0.021	0.026

Эх сурвалж: СХЗ-ны тайлангаас судлаачийн хийсэн тойм

Санхүүгийн зохицуулах хорооноос 2017-2020 онуудын хооронд 32,241 санхүүгийн тайланд зайнаас хяналт шалгалт хийж 330 албан шаардлага хүргүүлж нийт 841.2 сая төгрөгийн торгууль ногдуулж 521.1 сая төгрөгийн биелэлтийг хангуулсан байна. 2018 оноос торгууль шийтгэлийн

Хүснэгт 9. Санхүүгийн зохицуулах хорооны 2017-2021 оны газар дээр нь хийсэн хяналт шалгалтын үр дүн

№	Салбар	2017	2018	2019	2020	2021	Нийт
1	Банк бус санхүүгийн байгууллага	110	557	105	76	15	999
2	Даатгалын байгууллага	67	212	144	15	2	447
3	Үнэт цаасны зах зээлийн байгууллага	37	79	40	29	44	249
4	Хадгаламж зээлийн хоршоо	29	241	32	18	2	359
5	Үл хөдлөх эд хөрөнгө, үнэт металл	-	-	-	-	123	123
	Нийт	243	1,089	321	138	263	2,054
1	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн	62	52	42	42	47	198
2	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон	45	22	70	70	66	207
3	Тусгай зөвшөөрөл сэргээсэн	16	57	16	16	11	105

Эх сурвалж: СХЗ-ны тайлангаас судлаачийн хийсэн тойм

Санхүүгийн зохицуулах хорооноос 2017-2021 онуудын хооронд 2,054 аж ахуйн нэгжид газар дээр нь хяналт шалгалт хийсний 48% нь банк бус санхүүгийн байгууллага, 22% нь даатгалын байгууллага, 12% үнэт цаасны байгууллага, 17% нь хадгаламж зээлийн хоршоо, 6% үл хөдлөх эд хөрөнгө, үнэт металлын байгууллага байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд газар дээрх хяналт үр дүнгээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн 198, тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон 207, тусгай зөвшөөрөл сэргээсэн 105 байна.

Хүснэгт 10. Төрийн аудитын байгууллагаас хийсэн хяналт шалгалтын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлтүүд	2018	2019	2020	2021	Нийт
1	Санхүүгийн тайлангийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ	3.68	1.07	2.45	2.43	2.22
2	Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ	0.55	0.65	0.24	0.08	0.36
3	Нэг байгууллагад ногдох нийт зөрчлийн хэмжээ	4.23	1.72	2.69	2.51	2.58

Эх сурвалж: Судлаачийн хийсэн тооцоолол

Дүгнэлт

Манай улсын хувьд санхүүгийн хяналт шалгалт нь төрийн аудитын хяналт шалгалт, төрийн захиргааны хяналт шалгалт гэсэн ангиллаар хийгдэж байна. Төрийн аудитын шалгалт нь санхүүгийн тайлангийн аудит, нийцлийн болон гүйцэтгэлийн аудит гэсэн чиглэлээр, төрийн захиргааны хяналт шалгалт нь татварын, нийгмийн даатгалын, банкны, гаалийн, санхүүгийн болон дотоод аудитын, санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт зэрэг чиглэлүүдээр хийгдэж байна. Эдгээр хяналт шалгалтын үр дүнг нэгтгэн дүгнэвэл:

- Үндэсний аудитын газраас хийсэн аудитын шалгалтаар санхүүгийн тайлангийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ 2020, 2021 онд өссөн хандлага ажиглагдаж байна. Тухайлбал 2019 онд нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ 1.07 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 2.45 тэрбум төгрөг болж 129%-иар, 2021 онд 2.43 тэрбум төгрөг болж 127%-иар тус тус өссөн байна. Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын нэг байгууллагад ногдох зөрчлийн хэмжээ 2020, 2021 онд буурсан байна. Сүүлийн 12 жилийн хугацаанд төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн болон нийцэл, гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр нэг байгууллагад ногдох зөрчлийн дүн 2.58 тэрбум төгрөг байна. Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн хэмжээ арилахгүй, буурахгүй тогтвортой байгаа нь аудитын шалгалтын үр дүн хангалтгүй, төсвийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан бэлтгэх үйл ажиллагаа нь стандарт, хууль эрх зүйн хүрээнд нийцэхгүй байгааг харуулж байна.
- Татварын албаны 2013-2020 оны хооронд хийсэн сүүлийн 8 жилийн хяналт шалгалтын дүнгээр 51,306 шалгалт хийснээс 82.3% буюу 42,216 зөрчил илэрсэн ба зөрчлийн мөнгөн дүн нь 31,723.9 тэрбум төгрөг,

ногдуулсан төлбөр 2,980.3 тэрбум төгрөг байна. Хяналт шалгалтын тоо сүүлийн жилүүдэд буурсан хандлагатай байгаа боловч 2017 оноос хойн нэг шалгалтад ногдох зөрчлийн дүн болон нэг актад ногдох төлбөрийн хэмжээ өссөн байна. Тухайлбал 2013 онд нэг шалгалтад ногдох зөрчлийн хэмжээ 0.17 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 4.6 тэрбум төгрөг болон өссөн байна. Татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил болон ногдуулсан төлбөрийн хэмжээ өсөх хандлагатай байгаа нь татварын хяналт шалгалтын үр дүн хангалтгүй, аж ахуйн нэгж, байгууллагууд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь харагдаж байна.

- Төрийн захиргааны төв байгууллагуудаас хийсэн санхүүгийн хяналт шалгалт, нийгмийн даатгалын байгууллагаас хийсэн хяналт шалгалт, санхүүгийн зохицуулах хорооноос хийсэн хяналт шалгалтуудаар илэрсэн зөрчил хэмжээ ч буурахгүй байгаа нь эдгээр хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Дээрх хийсэн судалгаа, дүгнэлтэд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг Үндэсний аудитын газар, Монгол банк, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Авлигатай тэмцэх газар, Шүүх, цагдаагийн байгууллагууд нь хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ашигладаг мэдээллийн нэгдсэн сан бий болгон харилцан уялдаатай хамтран ажиллах.
2. Энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлууд цөөн байгаа тул санхүүгийн хяналт шалгалтыг хөгжүүлэх, боловсронгуй болгох үүднээс төр, эрдэм шинжилгээний байгууллагууд энэ асуудлаар тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай. Хяналт шалгалтын байгууллагуудад цуглуулсан тоо, мэдээнүүдийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах.
3. Шалгагдагч байгууллагуудын нягтлан бодогч, санхүүч нар болон бусад шаардлагатай ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, хууль эрх зүйн ойлголтыг сайжруулах зорилгоор тогтмол сургалтад хамруулах.
4. Санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил болон буруутай этгээдэд хүлээлгэсэн хариуцлагын талаар тухай бүр нийтэд мэдээлдэг байх.

Ашигласан материал

- Авирмэд.Д, “Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, үр дүнгийн судалгаа”, Бизнес ба Инноваци, No.3, 2017
- Бурмаа.Н, “Үндсэн хууль үеэ өнгөрөөн өөрчлөгддөг, харин санхүүгийн хяналт оршин тогтносоор байдаг”, Политологи, No.489, 2018
- Өнөржаргал.А, “Үндэсний компаниудын дотоод аудитын төлөвшлийн судалгаа, дүгнэлт” Бизнес ба Инноваци, No.2, 2015
- Энхбат.А, Янжинсүрэн.Г, “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, сайжруулах арга зам”, Бизнес ба Инноваци, No.2, 2019
- Пүрэвдорж.О, Нүржигмаа.О, Мөнхтуяа.Г, “Нягтлан бодогчийн ёс зүйн асуудалд” УБ. Бизнес ба Инноваци, No.2, 2018
- Iryna Maksymenko1, Tatyana Melikhova “Accounting and analytical procurement of state financial control and directions of its implementation in ukraine”, Baltic Journal of Economic Studies, Vol. 3, No. 5, 2017
- Агваан.Н, Хүрэлчулуун.Н, “Санхүүгийн хяналт шалгалт” УБ. 2013
- Авирмэд.Д, Батгуяа.Д, Мөнхзул.Г, “Улсын секторын нягтлан бодох бүртгэл, хяналт” УБ. 2019
- Алтанзаяа.Г, “Санхүүгийн хяналт шалгалт” УБ. 2011
- ММНБИ Редактор Л.Энх-Амгалан.Л, “Санхүүгийн тайлагналын гарын авлага”. УБ. 2008
- Цэрэнтоогоо.А, Насанбаяр.Б, “Банкны хяналт шалгалт, шинжилгээ” УБ. 2013
- Энхбат.А, Янжинсүрэн.Г, “Төрийн /нийтийн/ төсөв, санхүүгийн хяналт шалгалт: Онол, практик, арга зүй, тогтолцоо, эрх зүйн орчих”. УБ. 2020
- МУИХ, “Төрийн хяналт шалгалтын тухай хууль” УБ. 2003
- “Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж зарим тушаал шийдвэр” УБ. 2019
- Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага, “Лимагийн тунхаглал” Лима, 1977
- Үндэсний аудитын газар, “Үйл ажиллагааны тайлан 2010-2021”
- Санхүүгийн зохицуулах хороо, “Үйл ажиллагааны тайлан 2017-2021”
- <http://www.legalinfo.mn>

<http://mta.mn/>

https://www.audit.mn/?page_id=1246

<http://www.frc.mn/>

<http://www.ndaatgal.mn/v1/>

<https://www.customs.gov.mn/>